



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтооолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн албан хэрэгцээнд зориулан 150,000,000.00 (нэг зуун тавин сая) төгрөгт багтаан автомашин худалдан авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн өрөнхийлөгч Д.Рэгдэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

3.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000077

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 02 дугаар сарын 11.-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх ухааны Академийн худалдан авах автомашины техникийн  
үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Суудлын тоо 8, хөдөлгүүрийн багтаамж 3500 cc хүртэл /шинэ/	ш	1	150,000,000.00
<b>Нийт дүн</b>			1	<b>150,000,000.00</b> <b>(нэг зуун тавин сая)</b>